



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠲᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1/31

Алтай хот

**Дарив сумд хяналтын цэг ажиллуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дарив сумд хууль бусаар ашигт малтмал олборлох хөдөлгөөн идэвхтэй байгаа тул Хужирт багийн “Дэрстэйн эх” нэртэй газрыг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс нэг сарын хугацаанд, Жавхлант багийн “Баагийн улаан” нэртэй газрын хяналтын цэгийг үргэлжлүүлэн 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хамгаалж, халдашгүй байдлыг нь хангах чиг үүрэг бүхий хяналтын цэг ажиллуулсугай.

2. Хяналтын цэгийн ажиллах бүрэлдэхүүний хуваарь, гарах зардлыг хавсралтаар баталж Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ц. Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Эргүүл хяналтыг чанартай гүйцэтгэн, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж, цаг үеийн байдлыг өдөр бүр танилцуулж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), Дарив сумын Засаг дарга (М. Мэндбаяр)-д тус тус даалгасугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн 4 дугаар захирамжийн хавсрагт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Хяналтын цэгийн нэр	Алба хаагчын тоо	Хэдэн өдөр	Нэг хоногийн хоолны зардал	Нийт дүн	Тайлбар	
1	Хоол	Цагдаагийн алба хаагч	4	31	80,000	2,480,000	Нийт 8 алба хаагч 31 хоног 24 цагаар үүрэг гүйцэтгэх	
		Бусад төрийн алба хаагч	4	31	50,000	1,550,000		
Хоолны дүн						4,030,000		
	Нэр төрөл	Үүрэг гүйцэтгэх чиглэл	Машины тоо	Хэдэн өдөр	Өдөрт зарцуулах шатахуун	1 литр шатахууны үнэ	Нийт дүн	Тайлбар
2	Шатахуун	Өдрийн үүрэг гүйцэтгэх машин 1	1	31	30	2,900	2,697,000	2 автомашинаар эргүүл, постод гарах, 31 хоног ажиллах
		Өдрийн үүрэг гүйцэтгэх машин 1	1	31	30	2,900	2,697,000	
		Ээлж солилцох машин	1	6	118	2,800	1,982,400	7 хоног тутамд ээлж солих 560 км сард 5-6 удаа
		Аймгаас хяналт шалгалтаар	1	6	160	2,800	2,688,000	Хяналт шалгалт хийх
Шатахуун дүн						10,064,400		
3	Нүүрс, мод	Постны гэрт	Постны тоо	Хэдэн өдөр	1 тн нүүрс	Нүүрсний үнэ	Нийт дүн	Тайлбар
			2	31	4	250,000	1,000,000	
			2	31	30	8,000	240,000	
Нүүрс, модны дүн						1,240,000		
Дарив сумын өмнөх хяналтын цэг ажиллуулахад шаардагдсан бензиний зардал						4,000,000		
Нийт дүн						19,334,400		